

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ТӨСВИЙН  
ЗАРЦУУЛАЛТЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХИЙСЭН НИЙТИЙН  
СОНСГОЛЫН ТЭМДЭГЛЭЛ

№03

2023 оны 11 дүгээр сарын 01-ны өдөр

Хүрэмт

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төсвийн зарцуулалтын 2022 оны төсвийн зарцуулалтад төсвийн хяналтын сонсголыг 2023 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн 15<sup>30</sup> цагт сумын ИТХ-ын ажлын өрөөнд эхлэв.

Нийтийн сонсгол даргалагчаар ИТХурлын төлөөлөгч Ч.Батжаргал, дуудагдсан албан тушаалтан ерөнхий нягтлан бодогч Б.Саруул, Б.Батцэцэг ЗДТГ-ын дарга. Оролцогчоор ИТХ-ын Н.Галбадрах, ИТХ-ын төлөөлөгч П.Лхагвадорж, ИТХ-ын төлөөлөгч Т.Бямбасүрэн, Т.Лхагважав Соёлын төвийн дарга, Г.Долгорболоож Соёлын төвийн нярав, С.Энхмаа шуудан холбооны эрхлэгч, Д.Оюунжаргал ИТХ-ын төлөөлөгч, Д.Заяадаваа ЕБСургуулийн дотуур байрны жижүүр. Ажиглагчаар: Ч.Туул ЗДТГазрын архив, бичиг хэргийн эрхлэгч, Д.Должинсүрэн Нягтлан бодогч, Цэрэндагва Хүрэмт багийн иргэн, ИТХ-ын нарийн бичгийн дарга Ш.Элбэгжаргал, ИТХурлын ажлын албаны мэргэжилтэн Л.Золжаргал нар оролцов.

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Дуудагдсан албан тушаалтан 13 бүртгүүлснээс захиалагч талаас ЗДТГ-ын дарга Б.Батцэцэг, ерөнхий нягтлан Б.Саруул 2 ирсэн байна. Засаг дарга З.Түмэндэмбэрэл Алтантал багийн иргэдийн Нийтийн Хуралтай учир чөлөө авсан. Гүйцэтгэгч алаас сонсголд ирсэн хүн байхгүй. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төсвийн зарцуулалтын 2022 оны төсвийн хяналтын сонсгол үүгээр эхэлж байна. Сонсгол удирдах дараалал, баримтлах дэг танилцуулъя. /Материал хавсаргав/

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төсвийн зарцуулалтын 2022 оны төсвийг ерөнхий нягтлан бодогч дуудагдсан албан тушаалтан Б.Саруул танилцуулна. /Материал хавсаргав/

Сонсгол дараглагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Ерөнхий нягтлан Б.Саруулд баярлалаа. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төсвийн зарцуулалттай холбоотой асуулт асуух оролцогчид байна уу? Нэрээ өгөөд явчихъя. Оролцогч ИТХ-ын төлөөлөгч П.Лхагвадорж, оролцогч ИТХ-ын төлөөлөгч Н.Галбадрах, оролцогч ИТХ-ын төлөөлөгч Ц.Дэчинравдан.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Ц.Дэчинравдан-Гүйцэтгэсэн ХХК-наас төлөөлөл ирээгүй учраас захиалагч талаас нь асууя. Манай багт 2 эвдэрсэн худаг байгаа байгаа засаж өгөх талаас нь арга хэмжээ авч өгөөрэй. Чанартай ажил хийх хэрэгтэй. Худаг хийсэн Нямдорж хийсэн ажлынхаа тайлангаа тайлангаа тавих хэрэгтэй байлаа.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч П.Лхагвадорж-Манай багт хийгдсэн худагны кольцо эвдэрээд хайгуул хийж байсан ХХК-аар янзлуулсан. Худаг засварын ажил чанаргүй болсон.



Ерөнхий нягтлан бодогч Б.Саруул-Хамтран ажиллах гэрээн дээрээ ажлыг чанартай хийлгэх талаар заалт оруулж өгсөн. Шууд гэрээ хийсэн. Багийн дарга малчидаас нь санал аваад хийгдэх ажил дээр оруулж өгдөг. Эрэмбэнд орж ирсэн мөртлөө ажил хийгдээгүй бол дэмжигдээгүй гэсэн үг. Малчдаас гарч ирсэн санал дээр эрэмблэгдэж хийгдэнэ. Хүрэмтийн худагыг Засаг дарга байсан Т.Нямдаваа 2 худагыг өөрөө яваад янзалсан.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч П.Лхагвадорж-Бүтээн байгуулалт хийсэн хүмүүс нь ирээгүй байна. Үр дүн муутай нийтийн сонсгол болж байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Соёлын төв хөшөөний хайс хийсэн байна. Хэдэн хайс хийсэн бэ? Нэг хайс хийхэд зарцуулагдсан тооцоон дээрээ тайлбар хэлнэ үү? Сумын гэрэлтүүлгийн асуудал яасан бэ? Сумын төвд ИТХ-аас 8 төлөөлөгчид байдаг. Суманд хийгдэж байгаа ажил дээр хяналтаа тавихгүй яасын. Гэрэлтүүлэгийн ажилд 20 сая төгрөгнөөс 14 сая төгрөг нь зарцуулагдсан байна. Хариуцалга тооцох хүнгүй болчихоор төсвийн мөнгө үнэгүйдээд дуусах юм.

ЗДТГ-ын дарга Б.Батцэцэг-ИТХ-ын төлөөлөгч Даваасүрэнтэй гэрэлтүүлэгийн ажлын талаар ярьсан. Хамт гэрэлтүүлэгийн ажил хийсэн Галмандах нь нийтийн сонголд ноднин ч ирээгүй. ИТХ-ын төлөөлөгч нь хүртэл зугтаад алга болчихдог. Даваасүрэнтэй яриад тавьсан гэрэлтүүлгийн чанараа сайжруул гэж хэлсэн боловч ажил хийгдээгүй. Гэрэлтүүлэгийн ажлыг хүлээж аваагүй. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийсэн ажлууд дээр хяналт хийсэн. Сумын төвд барьсан зоорь хуучин материалаар хийгдсэн, ногоон байшин дотор талаасаа тааз нь нурж унасан, 00-ийн хаалга эвдэрсэн байсан.

Сонсгол дараглагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Орон нутгийн хөгжлийн хөрөнгөөр хийгдсэн Соёлын төвийн хайсны талаар Соёлын төвийн соёлын өвийн ажилтан Г.Долгорболоож хариулт хэлнэ.

Оролцогч соёлын өвийн ажилтан Долгорболоож-Соёлын төвийн соёлын өвийн ажилтаннаар ажиллдаг. Соёлын өвийг хамгаалах хайсны гүйцэтгэл дээр хариулт хийе. /Материал хавсаргав/

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Тодорхой мэдээлэл өгсөн оролцогч Г.Долгорболоождоо баярлалаа.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Д.Оюунжаргал-Гүйцэгэгч ХХК-наас төлөөлөлүүд нийтийн сонсголд ирээгүй болохоор захиалагч талаас ЗДТГ-ын мэргэлжилтэнүүд тайлбар хийж байна. Худаг засварын ажил чанаргүй хийгдсэн кольцоонууд нь ажилахаа больсон. Засвар хийсэн худагаа хариуцуулаад өгдөггүй учраас эзэнгүйдээд дуусдаг. Гэрэлтүүлгийн хувьд тусгал Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төсвийн хөрөнгөөр 2022 онд тусгал сайтай 4 ширхэг гэрэлтүүлэг хийнэ гэж байсан гэтэл нарны гэрлээлр ажилладаг гэрэл сайн гээд энэ гэрэлтүүлэгүүдийг тавьсан. 200 в хүчин чадалтай хамгийн муу тусгалтай гэрэлтүүлэгүүдийг тавьсан. Сайн нь 500 вт-ын хүчин чадалтай байдаг. Сүүлд үлдэгдэл 6,000.000 сая төгрөгөнд тавьсан 2 гэрэлийн нэг нь асахаа байсан байна лээ." Өв од" ХХК манай сумтай ямар холбоотой юм бэ? Өөр ХХК-аар хийлгэж болдоггүй юм уу? Сургуулийн ард хийгдсэн сагсны тайлбайг хийх захирал Оюунболд нь ирсэн байсан. Харилцаа хандлага муутай хүн байн лээ. "Өв од" ХХК манай сумтай ямар холбоотой юм. Өөр ХХК-наар хийлгэж болдоггүй юм уу?



Оролцогч ерөнхий нягтлан бодогч Б.Саруул-ЕБСургууль, Соёлын төв 2-т энэ ХХК-тай гэрээ хий гэж хэлээгүй.

Оролцогч ЗДТГ-ын дарга Б.Батцэцэг-4,5 сая төгрөгөнд гэрээ хийх газар олддоггүй. 4,5 сая төгрөгөнд ийм хэмжээний хайс хийхгүй. Хайс хийсэн хөдөлмөрийн хөлс ордоггүй. Өөрсдөө хийдэг.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Н.Галбадрах-Сонсголыг үр дүнтэй болгомоор байна. Гүйцэтгэсэн ХХК ирдэггүй гээд сууж байдаг харамсалтай юм. Эргүүлээд хариуцалга тооцдоггүй болохоор тоглоом болж байна. Ашиг сонирхол явагдаад байна уу гэж харагдаж байна. Захиалгагч, гүйцэтгэгч хоёрын нэг нь ирээгүй байхад бид нар энд суух шаардлагтай юм уу? 2020 оноос хойш ИТХ-ын төлөөлөгчид олонхи болоод 100 жилдээ бэлтгээд болчих болов уу гэж бодож байлаа. Цалингаа аваад явж байгаа юм бол хөрөнгийнхөө төлөө тэмцдэг байх хэрэгтэй. ЗДТГ-ыг 2024 онд ямар ажил хийж, яаж ажиллахыг харж байя. 20 сая дотроо тендер зарлахгүй бид хийнээ гээд л явдаг. Ногоон байшингийн асуудал эхнээсээ харгадаад явж байна.

Ороцогч ерөнхий нягтлан бодогч Б.Саруул-Хэвлэл мэдээлийн байгууллагаас ороцуулахгүй гээд байсан. Эхлээд бүртгүүлж баймаар юм даа. Шийдвэр гаргаж байгаа хүн нь солигдоод явдаг. Ногоон байшингийн хувьд аймгаас хөрөнгө оруулалт, хөгжлийн газар, барилга хот байгуулалтын газраас ажлын хэсэг ирээд хүлээж авсан. Хүлээж авахдаа сайн баригдсан гээд хүлээж авсан.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Н.Галбадрах-Би ИТХ-ын төлөөлөгч. Иргэддээ ил тод мэдээлэл өгөх үүрэгтэй. Ажлаа өгөөд явсан хүнд буруугаа өгөхөө болих хэрэгтэй.

Сонсгол дараглагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Санал дүгнэлтээ хийе. Хэн хэн байна. Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Т.Бямбасүрэн, ИТХ-ын нарийн бичгийн дарга Ш.Элбэгжаргал. Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Т.Бямбасүрэн та дүгнэлтээ хэлнэ үү?

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Т.Бямбасүрэн-2022 оны орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын талаар мэдээлэл сонслоо. Техникийн тодорхойлтоо маш сайн гаргаад, шалгаад хийсэн ажлаа хүлээгээд авахад болно. Сумын төвд ИТХ-ын 8 төлөөлөгч байгаа мөртлөө яагаад энэ ажлууд дээр хяналт тавьж шалгаагүй юм бэ? муу ажиллаж байна. ИТХ-ын зүгээс ажил гүйцэтгэж байхад нь хяналт хийгээд шалгаших хэрэгтэй. Гэрэлтүүлэгийн ажил дээр нийтийн сонсгосол хийлгэх хэрэгтэй. Үний хөөрөгдөл гэх мэт зүйлс нөлөөлдөг.

Оролцогч Соёлын төвийн соёлын өвийн ажилтан Г.Долгорболоож- 5 үл хөдлөх газрын хайсан хашаандаа материалаа хүргэх гээд өөрсдөөсөө 200,000 төгрөг гаргаад гагнуурчин хөлслөөд хайсаа гагнуулж хийсэн.

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Хайсан хашааны зарцуулалтыг сонссон. Тайлбар хангалттай байсан. Дараагийн оролцогч ИТХ-ын нарийн бичгийн дарга Ш.Элбэгжаргал дүгнэлтээ хэлнэ үү?

ИТХ-ын нарийн бичгийн дарга Ш.Элбэгжаргал-Энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр энд Тарагт сумын 3300 хүнийг төлөөлөөд 10 хэдэн хүн сууж байна. Аливаа ажил үр дүнтэй байх хэрэгтэй. Нодин ч бас ингээд сууж байсан. Цаашид яах вэ? Энэ ажлуудыг яаж засах вэ?

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Н.Галбадрах-Улс орон даяар санхүүгийн албаны даргаас сонсогдож байна хуучин Засаг дарга руу халдаад яяваад байна. байхад нь хэлж яриад явахгүй.



Дуудагдсан албан тушаалтан ерөнхий нягтлан бодогч Б.Саруул-Захиалагч тал нь нэг хүн шийдвэр гаргаж байгаа учраас Т

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Н.Галбадрах-Янз бүрийн гарц нь яах вэ?

Дуудагдсан албан тушаалтан Б.Батцэцэг-Шинэ Засаг дарга ажлаа аваад хамтраад ажиллаад явж байна. Дараа жил алдаагаа засаж ажиллана.

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Засаг дарга, ЗДТГ хамтраад ажиллаад явж байна. Техникийн тодорхойлолт дээрээ анхаарч ажиллаж баймаар байна төсөвөө батлуулах дээрээ гүйцэтгэгч талтай гэрээ хийхдээ гэрээний заалт дээрээ мөнгөнөөс нь авч үлээд, нийтийн сонсголд оролцуулсны дараа үлдэгдэл мөнгийг нь шилжүүлдэг заалт оруулж болдоггүй юм уу?

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Н.Галбадрах-Ямарч дүгнэлт хийх боломжгүй болоод байна. Аятайхан дүгнэлт хийчихмээр байна. Дараагийн сонсголоо анхаарч хийх хэрэгтэй. Гүйцэтгэгч талаа дараагийн сонсголд яаж оролцуулах вэ?

Дуудагдсан албан тушаалтан Б.Батцэцэг-Гэрээнд заавал нийтийн сонсголд орлцуулсны дараа үлдэгдэл мөнгийг нь шилжүүлнэ гэж болохгүй. Ажил гүйцэтгэж байгаа талын хүн чанарын л асуудал.

Оролцогч ИТХ-ын төлөөлөгч Д.Оюунжаргал-Цаашид хийгдэх ажлынхаа техникийн тодорхойлолтоо судалгаатай, зураг төсөлөө сайн гаргаж ажиллаарай. Хүрэмт багийн ИТХ-ын 8 төлөөлөгч гэсэн техникийн тодорхойлолтоо цаашид гаргаж ажлаар байна. Хяналтын ажлаар өөрийнхөө хэмжээнд явдаг. Заримдаа ИТХ-ын төлөөлөгч 8 лаа явдаггүй. Орон нутгийн сангийн үзүүлэлтээрээ манай сум улсад 62 дугаар байр, аймагтаа 5 дугаар байранд орсонд баяр хүргэе.

Сонсгол даргалагч ИТХ-ын төлөөлөгч Ч.Батжаргал-Өөр дүгнэлт хийх оролцогч байна уу? Байхгүй бол хэдэн зүйл хэлий. Хүрэмт багийн 8 төлөөлөгч хяналт хийж явдаггүй биш явдаг. 8-лаа явдаггүй нь учир дутагдалтай. Цаашид анхаарч ажиллана. Идэвхитэй ажилладаг ч төлөөлөгч бий. Хувь хүний хандлага харагдаж байдаг. Болохоосоо болохгүй хүртлээ явдаг. Өнөөдрийн нийтийн сонсголийн үр дүн гарах ёстой. Цаашдаа зөв голдиролдоо ороод явах байх. Өнөөдрийн сонсголд холоос ирсэн ИТХ-ын төлөөлөгчид, мэдээлэл тайлбараа тавьсан ерөнхий нягтлан бодогч Б.Саруул, ЗДТГ-ын дарга Б.Батцэцэг нартаа баярлалаа. Цаашдын ажилд нь амжилт хүсье. Нийтийн сонсгол албан ёсоор хаалаа.

Нийтийн сонсгол 17 цаг 05 минутад өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХЯНАСАН

ИТХ-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ш.ЭЛБЭГЖАРГАЛ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

ИТХ-ЫН АЖЛЫН АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН / *Золжаргал* Л.ЗОЛЖАРГАЛ

